1. Тайлант онд тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous Accounting System 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигласан. Мөн хичээл, сургалтын үйл ажиллагаанд математикийн “Эдүтэн”, англи хэлний “Персон” цахим программуудыг “АЙ И ДИ СИ” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглаж байна.
2. Тус байгууллагад хоол, унааны хөнгөлөлтийн төсөв батлагдаагүй байсан хэдий ч Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дугаар албан бичгээр ирүүлсэн хоол, хөнгөлөлт олгох тухай чиглэлийн дагуу сургуулийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны А/05 дугаар тушаалаар ажилтанд хоол, хөнгөлөлт олгохоор шийдвэрлэсэн байна.

Үүний хүрээнд нэг ажилтанд өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон, тайлант онд нийт 19,145.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг олгосон байна.

1. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын ЕБС-ын бүтэц, орон тоог сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар 49 орон тоотойгоор баталсан байна. Харин жилийн эцсийн байдлаар байгууллага нь 45 орон тоотой ажилласан бөгөөд орон тооны цомхотгол хийгээгүй, батлагдсан орон тооноос 4 орон тоо дутуу ажилласан байна. Тухайлбал: сэтгэл зүйч, хоол зүйч, химийн багш, эмчийн орон тоо тус тус дутуу ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Үүрцайх нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,924,066.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,240.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 12,506.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн 95.8 хувийг зарцуулж 87,484.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 52,821.6 мянган төгрөгийн 9 гүйлгээ, орлогын 732,371.2 мянган төгрөгийн 37 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 29 шийдвэрийг тус тус бүрэн байршуулж мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар 4,930.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөрчлийг тайлант хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн. Үүнд:

- Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025.01.20-ны өдрийн тогтоолоор "Марал Баян Өргөө" ХХК-ний эзэмшлийн дулаанаар түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний төсөвт байгууллагад борлуулах эзлэхүүнээр тооцох тарифыг шинэчлэн тогтоосон байна. Тус тогтоолын 2 дах заалтад "Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд"-нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй." гэж заасан ба ЗХХАЭ-д 2025.02.03-д нийтлэгдсэн байхад 2025 оны 01 дүгээр сарын 1-ний эхлэн шинэ тарифаар гэрээ байгуулан 4,930.4 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн тул 2025 оны 12 сарын халаалтын санхүүжилтээс суутган тооцох зөвлөмжийг хүргүүлж тайланд оны эцэст суутгаж тооцсон байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын ажлыг "Номгон Аудит" ХХК гүйцэтгэж, нийт 61,541.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	151.8	1	151.8	100
Албан шаардлага	1	1,442.9	1	1,442.9	100
Зөвлөмж	1	59,947.1	1	59,947.1	100
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Багш ажилчдад олгох хоолны хөнгөлөлтийг төсвийн хуваарьт хоолны зардлаар батлахгүй, цалингийн хэмнэлтээс олгож байгаа асуудалд аймгийн Боловсролын газарт хоолны зардлыг ТЕШ-ийн төсөвт төлөвлөн батлуулж олгох талаар анхаарч ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,041.2 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Ажилтнаас шүүхийн шийдвэрийн дагуу суутгал хийхдээ 45.1 мянган төгрөгийг илүү суутгасан бөгөөд санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.
2. Боловсролын яамнаас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 1,996.1 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг орлогод аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх" , оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 15,975.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөрчлийг арилгах 14,040.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, төсвийн үр ашгийг сайжруулах 1,934.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 13,934.8 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус гэж тооцсон ба бусад зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын хэмжээнээс 10,466.3 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Тайлант хугацааны хүүхэд хамгааллын батлагдсан зардлын 1,934.7 мянган төгрөгийн төсвийг зарцуулахдаа үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, зорилтод арга хэмжээг бүрэн хамруулж зарцуулаагүй байна.

Энэ нь Боловсролын сайдын А/249 дугаар тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах зааврын 2.2 " Тухайн жилд сургуулийн хүүхэд хамгааллын зардлын батлагдсан төсвийн 50-с аас доошгүй хувийг энэ зааврын 2.5.3-д заасан үйл ажиллагаанд, 30 хүртэл хувийг энэ зааврыг 2.5.2-т заасан үйл ажиллагаанд, 20 хүртэл хувийг 2.5.1-д заасан үйл ажиллагааны төлөвлөгөөг БЕХ-ын 34.1, 34.2-т заасан зөвлөл батална" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхэд хамгааллын зардлыг батлагдсан заавар журмын дагуу төлөвлөж зорилтод арга хэмжээнд үр дүнтэй зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

5.1.1 Нөхөн хангалтын зардлаар 13,934.8 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авсан ба байгууллагын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэж эрэмбэлсэн жагсаалт гаргаж түүний дагуу худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Боловсролын сайдын А/249 тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.1-т "Шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээнд үндэслэн байгууллагын түвшинд хэрэгцээг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



эрэмбэлж, төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчид хүргүүлэх"-гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн хангалтын зардлаар хөрөнгө бэлтгэхдээ Боловсролын сайдын А/249 тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" -ийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.2 Нийгмийн даатгал мэдээлэх цалинг 360.4 мянган төгрөгөөр бодсон байхад 800.0 мянган төгрөгөөр НДШ-д мэдээлсний улмаас цалингийн дүнг 439.6 мянган төгрөгөөр, НДШ-ийг 105.5 мянган төгрөгөөр тус тус илүү мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" - гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.3 Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь ҮХ-ийн бүртгэлд 20,713 м2-р, газрын эзэмших гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 21,639 м2-р тус тус зөрүүтэй бүргэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12 "Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана"- гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ГХБХБГ-тай тооцоо нийлэн тулган баталгаажуулж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шүүхийн шийдвэрийн дагуу суутгал хийхдээ 45.1 мянган төгрөгийг илүү суутгасан бөгөөд санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.	1	45.1	1	45.1			1	45.1				
Боловсролын яамнаас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 1,996.1 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг орлогод аваагүй байна.	1	1,996.1	1	1,996.1			1	1,996.1				
дүн	2	2,041.2	2	2,041.2			2	2,041.2	0	0	0	0

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхэд хамгааллын батлагдсан төсвийг зарцуулахдаа үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулалгүй зорилтод арга хэмжээг бүрэн хамруулж зарцуулаагүй байна.	1	1,934.7				-	1	1,934.7
Нөхөн хангалтын зардлаар 13,934.8 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд байгууллагын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэж эрэмбэлсэн жагсаалт гаргаж түүний дагуу худалдан авалт хийгээгүй байна	1	13,934.8			1	13,934.8		
НДШ- тооцох цалинг 360.4 мянган төгрөгөөр бодсон байхад 800.0 мянган төгрөгөөр НДШ-д мэдээлсний улмаас цалингийн дүнг 439.6 мянган төгрөгөөр, НДШ-ийг 105.5 мянган төгрөгөөр тус тус илүү мэдээлсэн байна	1	105.5			1	105.5		
Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь ҮХ-ийн бүртгэлд 20,713 м2-р, газрын эзэмших гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 21,639 м2-р тус тус зөрүүтэй бүргэгдсэн байна.	1				1	0		
Нийт дүн	3	15,975.0			2	14,040.3	1	1,934.7

-----oO-----

Дээрх зөвлөмж акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар

58/0671855 -БНА-2026/030
-НА-СТА-ТЭМБ.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтны нийгмийн даатгалд мэдээлбэл зохих цалинг 360,400 төгрөгөөр тооцох ёстой байсан боловч НДШ төлөх цалинг 800,000 төгрөгөөр буюу 439,600 төгрөгөөр илүү мэдээлснээс шалтгаалан НДШ-ийг 105,000 (нэг зуун таван мянга) төгрөгөөр илүү мэдүүлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.2."орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", Төсвийн тухай хуулийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" - гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сар бүрийн НДШ-ийн тайлан, мэдээллийг хуульд заасан хувь хэмжээ, бодогдсон цалин дээр үндэслэн бодож байх, цаашид зөрчлийг таслан зогсоож

6426090185

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 05 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:



Д.ДАВААДОРЖ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 16/4067/255-БМН-2026/090 - Номгон
- НА-СТА-ТШС.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нөхөн хангалтын зардлаар 13,934,800 (Арван гурван сая есөн зуун гучин дөрвөн мянга найман зуу) төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авсан ба байгууллагын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэж эрэмбэлсэн жагсаалт гаргаж түүний дагуу худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Боловсролын сайдын А/249 тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.1-т "Шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээнд үндэслэн байгууллагын түвшинд хэрэгцээг эрэмбэлж, төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчид хүргүүлэх"-гэсэн заалттай нийцэхгүй байна

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

096426090053

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нөхөн хангалтын зардлаар хөрөнгө бэлтгэхдээ Боловсролын сайдын А/249 тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу зарцуулж байх, цаашид зөрчлийг таслан зогсоож хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР



Д.ДАВААДОРЖ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 21/НОТ-ХСС/БНА-2026/070-
- 11А - ЭТА - ТУИС

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмшлийн газар нь газрын эзэмших эрхийн гэрчилгээ болон egazar.gov.mn цахим санд 21,639 м²-аар бүртгэлтэй байгаа боловч нягтлан бодох бүртгэлийн үндсэн хөрөнгийн бүртгэлд 20,713 м²-аар бүртгэгдсэн нь 926 м²-ын зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12 "Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана"- гэсэнтэй нийцэхгүй байна

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

3426090069

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР



Д.ДАВААДОРЖ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно